



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 20 өдөр

Дугаар АБВЧ

Мандлагом

О.Билэгсайханыг шагнаж
урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 (а), Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Эрдмийн далай" цогцолбор сургуулийн сурагч О.Билэгсайхан нь Монгол Улсад зохион байгуулагдсан Зүүн Азийн аварга шалгаруулах шатрын тэмцээнд амжилттай оролцож, 3 дугаар байранд шалгаран, Дэлхийн шатрын холбооны дэд мастер цол хүртсэн тул аймгийн Засаг даргын "Хүндэт өргөмжлөл", мөнгөн шагналаар шагнасугай.

Хоёр. Мөнгөн шагналд 100000 (Нэг зуун мянга), хүндэт өргөмжлөл хэвлүүлэхэд 35000 (Гучин таван мянга), нийт 135000 (Нэг зуун гучин таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Ц.Эрдэнэсүрэн) нягтлан бодогч (Д.Нандицэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200824